

МЦХ ХК-ИЙН 2016 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОВЧ ТАЙЛАН

Эдийн засгийн үзүүлэлт

2016 онд МЦХ ХК нийт 20,852.0 сая төгрөгийн орлоготой ажиллахаас гүйцэтгэлээр нийт 22,400.4 сая төгрөгийн орлоготой ажиллаж орлогын төлөвлөгөө 107.4 хувийн биелэлтэй буюу 1,548.4 сая төгрөгөөр давж биелсэн. Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 3.6 хувиар буюу 736.9 сая төгрөгөөр давж биелсэн нь олон улсын ярианы үйлчилгээний орлого, суурин утасны үйлчилгээний орлого, интернэт үйлчилгээний орлого төлөвлөгөөнөөс давж биелсэнтэй холбоотой.

Компани 2016 онд нийт 21,220.9 сая төгрөгийн зардалтай ажиллахаас гүйцэтгэлээр 22,258.4 сая төгрөгийн зардал гарган 104.9 хувийн биелэлттэй буюу 1,037.5 сая төгрөгийн зардал хэтэрсэн үзүүлэлттэй байна. Үндсэн үйл ажиллагааны зардал 770.8 сая төгрөгөөр хэтэрсэн ба үүнд интернэтийн сувгийн түрээс, харилцан холболтын зардал, борлуулсан барааны өртөг, цахилгаан эрчим хүч, долгион ашиглалтын төлбөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил зэрэг зардлууд хэтэрсэн зэрэг үзүүлэлтүүд нөлөөлсөн.

Компанийн ашигт ажиллагааг тайлант хугацаанд 415.6 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 44.4 сая төгрөгийн ашигтай ажиллаж төлөвлөгөө 460.0 сая төгрөгөөр давж биелэн ашигт ажиллагаа сайжирсан.

2016 оны үндсэн үйл ажиллагааны талаар

1. Суурин утасны үйлчилгээ

- Суурин утасны орон нутгийн хэрэглэгчийн бусад сүлжээнд ярих ярианы тарифыг 50 төгрөг болгосон.
- Онлайн үйлчилгээг дэмжин ажилласны үр дүнд онлайн сайтын байнгын хэрэглэгчийн тоо 2 дахин нэмэгдсэн.
- Булган аймгийн 691 хэрэглэгч, Сэлэнгэ аймгийн 1,188 хэрэглэгч, Дархан-Уул аймгийн 616 хэрэглэгчдийг NGN станцад шилжүүлсэн.
- Хэрэглэгчийг халамжлах, нэмэгдүүлэх ажлын хүрээнд хөнгөлөлт, урамшууллын 10 хөтөлбөр, биечилсэн борлуулалтын 2 хөтөлбөр хэрэгжүүлж, суурин утас, интернэт, кабелийн телевиз, MiP70 үйлчилгээний хэрэглэгчидийн тоог нэмэгдүүлж чадсан.
- Суурин утас, интернэтийн хоёрлосон үйлчилгээний багц тарифыг нэвтрүүлэх зорилгоор нэг сарын хугацаатай урамшуулал зарлаж цаашид нийт хэрэглэгчдэд багцын үйлчилгээг нэвтрүүлэхээр төлөвлөөд байна.

2. Интернетийн үйлчилгээ

- Өндөр хурдны GPON интернэтийн үйлчилгээг анх ICT-EXPO-2016 үзэсгэлэнгээр хэрэглэгчдэд таниулсан ба эхний байдлаар ЭАТС-35 станцын харьяанд байрлах аж ахуй нэгж байгууллагуудад нэвтрүүлсэн.
- Идэвхгүй хэрэглэгчдийг идэвхжүүлэх зорилгоор нийт 4 хөтөлбөр хэрэгжүүлж, 2016 оны төлөвлөгөөг давуулан биелүүлсэн.
- Засгийн Газрын зүгээс мэдээлэл харилцаа холбооны салбарт баримталж буй бодлогын хүрээнд МЦХ ХК нь орон нутгийн интернэт хэрэглэгчийн хурдыг 2 дахин өсгөх, үнийг

2 дахин бууруулах шинэ тариф баталсан. Улмаар “Хурд өсч, үнэ буурлаа” таниулах, хоногшуулах хөтөлбөр хэрэгжүүлж ажилласан.

- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Худалдан авах ажиллагааны газраас зарласан хөдөө орон нутгийн 52 алслагдсан сум, суурин газарт утасгүй болон суурин өргөн зурвасын сүлжээ байгуулах, интернэтийн үйлчилгээ хүргэх тендерт шалгарч WiFi интернэт картын үйлчилгээг үзүүлж эхэлсэн. Нийт 166 суманд Миком WiFi интернэтийн картын үйлчилгээг хүргээд байна.

3. Кабелийн телевизийн үйлчилгээ

- National кабелийн телевизийг аналогои системээс тоон системд шилжүүлэх төсөл хэрэгжиж байна.

4. Лавлах үйлчилгээ

- Мэдээллийн баазыг хөгжүүлж 8,703 бүртгэлээр мэдээллийн баазаа баяжуулсан.
- 19001109.mn сайт бүрдүүлэлтийг хийн сайтад нийт 6,772 мэдээллийг шинэчилсэн.
- Хүргэлтийн үйлчилгээг идэвхжүүлж ном, CD, тоглолтын билет гэх мэт 2,341 ширхэг бараа, үйлчилгээг борлуулсан.

5. Олон улсын ярианы үйлчилгээ

- Шууд суваг бүхий /KT, KDDI, CUC, AT&T, GIC/ карьеруудтай гэрээг шинэчлэх, өмнөх жилүүдийн сувгийн төлбөр тооцоог дуусгах, шинэ гарц нээх зэрэг асуудлуудаар ажлын уулзалт зохион байгуулж карьер орнуудтай хамтран ажилласны үр дүнд гадаад тооцооны төлбөрөөс хэмнэлт гаргаж ажилласан.
- Орох ачааллыг нэмэгдүүлэх зорилгоор Global Integrated Communications (GIC) компанитай харилцан ашигтай гэрээ байгуулан ажилласнаар гадаад тооцооны орлого 28 хувиар давж биелсэн.
- Улс хоорондын ярианы ачаалал болон үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх зорилгоор ачааллын таталцал их улс оронтой шууд гарцыг нээх чиглэлээр GIC компанитай хамтран ажиллаж, төгсгөх тариф болон ачааллын хэмжээг харилцан тохиролцож IP холболт нээж хамтран ажиллаж байна.
- Олон улсын ярианы тарифыг хамгийн хямдаар тогтоох бодлогыг хэрэгжүүлж ажилласан.

MiP70 үйлчилгээ

- MiP70 үйлчилгээг бүх ухаалаг төхөөрөмжинд ашиглах боломжтойгоор шинэчлэл хийсэн.
- MiP70 үйлчилгээг таниулах, хоногшуулах, идэвхжүүлэлт тухай бүр хийж, биечилсэн борлуулалтийг тогтмол хийн ажиллаж байна.

Техник технологийн хүрээнд

- Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төр хувийн хэвшлийн уялдаа холбоог сайжруулан бүх нийтийн үйлчилгээний үүргийн хүрээнд “Цахим сум” төслийг Монгол Улсын 21 аймгийн 207 сум, суурин газар, хүн амд утасгүй болон суурин интернэтийн үйлчилгээг хүргэн ажилласан.
- МШХХГ-аас зарлагдсан сумдыг интернэтжүүлэх төслийн хүрээнд нэр бүхий 52 сумдыг холбож интернэт үйлчилгээг нэвтрүүлсэн.
- WiFi билл системийг ашиглалтанд оруулж WiFi төхөөрөмж суурилуулсан 160 гаруй сумдад урьдчилсан төлбөрт картын үйлчилгээг нэвтрүүлсэн.

- Улс хоорондын станц (IGW) нь Хятад /Chinaunicom/, Солонгос/КТ/, Америк/АТ&Т/чиглэлд TDM урсгалаар, Солонгос, Япон чиглэлд SIP trunk-аар ЭАТС-45, NGN, ЭАТС-3-тай нийт 12Е1 холбох шугамтайгаар тайлант хугацаанд ажилласан. 2016 оны 1-р улирлаас шинээр Сингапур/GIC/SIP урсгал нэмж ашиглалтанд оруулсан.
- МIP70 SIP үйлчилгээг нэвтрүүлэн хэрэглэгчийн гар утасны аппликэйшн нэвтрүүлэх ажил гүйцэтгэсэн.
- Интернэтийн үйлчилгээ болон үндсэн сүлжээг өргөжүүлэн шинэчлэх INI төслийн хүрээнд аймгийн төвүүд болон алслагдсан дүүргүүдийн роутерүүдийг ASR903 роутерүүдээр солих, төвд шинээр ASR9006 роутер суурилуулах, Firewall төхөөрөмж суурилуулах, VMWare виртуалчлалын систем суурилуулах ажлуудыг гүйцэтгэгч компаниудтай хамтран хийж гүйцэтгэсэн.
- Хуучин RADIUS сервер нь энгийн PC процессор дээр ажиллаж байгааг зориулалтын RADIUS server-р сольсон.
- Улаанбаатар хотын ADSL хэрэглэгчдийн google cache-д хандах трафикийг гадаад урсгалаас ялгаж явуулснаар firewall болон сүлжээний төхөөрөмжүүдийн ачааллыг багасгасан.